



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/225

Булган сум

Булган аймгийн түүх, дурсгалын  
сонсдог ном бүтээх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын өвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.8 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн түүх соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчлан таниулах зорилгоор аймгийн түүхийн сонсдог ном бүтээх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд: Г.Алдармөнх (Соёл урлагийн газрын дарга)  
Ж.Ганболд (Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга)  
Х.Батхишиг (Биеийн тамир, спортын газрын дарга)  
Ч.Амгалан (Хүнс хөдөө, аж ахуйн газрын дарга)  
А.Гантөмөр (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын  
дарга)

Сумдын Засаг дарга  
Сумдын Ерөнхий боловсролын сургуулийн түүх,  
нийгмийн ухааны багш нар

Булган аймгийн Түүхчдийн холбоо

Нарийн бичгийн дарга: Ё.Хулан (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн Соёл, спортын бодлого,  
зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн)

2.Сонсдог түүхийн ном бүтээх ажлын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



Sugar Ажил 2024 өдөр бүр Doc/2024/Захирамж

6324010310